



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

БАЯНХОНГОР АЙМГИЙН УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
АУДИТ

**АУДИТЫН КОД:** БНА-2021/156/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88089024      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор:                      М.Алтантуяа Утас: 99890393      Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт/эх хувь/ .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3.Аудитын тайлан .....	9
3.1. Ерөнхий зүйл .....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт .....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	15
Аудитын зөвлөмж .....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	16
4. Менежментийн захидал.....	16
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН УС, ЦАГ УУР,  
ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГА Ч.ОЮУНЧИМЭГ  
ТАНАА

2021. 02. 18 № 2/31

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил  
2021 А4 ТООТ

005020930

гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>227,761,917.67</u></b>	<b><u>267,702,168.40</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	803,919.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	803,919.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	803,919.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	226,957,998.67	267,702,168.40
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	193,049,711.02	236,586,356.45
35110	Тусгай зориулалттай материал	193,049,711.02	236,586,356.45
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	33,908,287.65	31,115,811.95
35410	Бичиг хэргийн материал	498,936.41	481,336.41
35420	Аж ахуйн материал	29,183,921.76	22,584,246.06
35440	Түлш, шатах тослох материал	00.00	463,200.00
35470	Бусад хангамжийн материал	4,225,429.48	7,587,029.48
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>757,884,144.38</u></b>	<b><u>786,491,068.46</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	757,884,144.38	786,491,068.46
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	531,742,144.38	560,349,068.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	522,894,788.20	522,894,788.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	-27,288,406.82	-35,658,073.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,941,400.00	78,608,973.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-36,941,400.00	-31,719,328.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	341,318,745.52	341,976,540.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-314,771,179.39	-322,691,720.41
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,573,239.08	26,169,716.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-21,674,208.90	-22,350,993.46
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,842,719.00	6,280,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,153,552.31	-3,160,833.27
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	226,142,000.00	226,142,000.00
39301	Программ хангамж	00.00	1,562,719.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,562,719.00
39303	Бусад биет бус хөрөнгө	226,142,000.00	226,142,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>985,646,062.05</u></b>	<b><u>1,054,193,236.86</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>985,646,062.05</u></b>	<b><u>1,054,193,236.86</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	985,646,062.05	1,054,193,236.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	587,740,743.91	587,740,743.91
51101	Өмч: - төрийн	587,740,743.91	587,740,743.91
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	44,776,628.17	113,515,324.98
51210	Өмнөх үеийн үр дүн	44,776,628.17	44,968,150.17
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	68,547,174.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	353,128,689.97	352,937,167.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>985,646,062.05</u></b>	<b><u>1,054,193,236.86</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,254,383,909.21</b>	<b>1,564,345,674.55</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>225,512,909.21</b>	<b>144,317,619.55</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	225,512,909.21	144,317,619.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	225,512,909.21	144,317,619.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	225,312,909.21	144,117,619.55
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,028,871,000.00</b>	<b>1,420,028,055.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,005,461,000.00	1,383,209,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,005,461,000.00	1,383,209,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	23,410,000.00	35,010,782.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	7,100,782.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,410,000.00	22,910,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	00.00	1,808,073.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	1,808,073.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,138,380,414.89</b>	<b>1,495,798,499.74</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,138,380,414.89</b>	<b>1,495,798,499.74</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,133,138,172.89	1,336,440,361.74
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	847,479,456.00	1,039,835,310.00
210101	Үндсэн цалин	676,031,256.00	729,445,224.00
210102	Нэмэгдэл	142,521,100.00	280,202,986.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,927,100.00	30,187,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	106,102,257.27	140,377,700.00
210201	Тэтгэврийн даатгал	72,247,657.27	98,784,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,463,700.00	10,398,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,770,900.00	8,665,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,692,700.00	1,733,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,927,300.00	20,796,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,502,302.00	25,258,914.00
210301	Гэрэл, цахилгаан	4,731,200.00	4,579,014.00
210302	Түлш, халаалт	18,696,102.00	20,415,900.00
210303	Цэвэр, бохир ус	75,000.00	264,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	38,545,124.39	32,344,647.70
210401	Бичиг хэрэг	2,994,100.00	1,310,740.00
210402	Тээвэр, шатахуун	14,060,850.00	15,574,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,219,259.00	2,768,932.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	551,500.00	635,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,768,979.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	16,950,436.39	12,055,275.70
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	464,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	464,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	33,853,905.60	42,073,700.34
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,871,832.60	40,314,600.34
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	33,100.00
210604	Урсгал засвар	2,982,073.00	1,726,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,443,800.00	2,981,000.00
210702	Дотоод албан томилолт	4,443,800.00	2,981,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,671,327.00	22,364,140.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,470,727.00	20,559,740.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	277,200.00	275,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	401,300.00	321,518.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,300.00	114,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	24,700.00	24,700.00

210807	Газрын төлбөр	386,100.00	1,068,382.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>62,540,000.63</b>	<b>30,740,449.70</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,540,000.63	30,740,449.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,242,242.00</b>	<b>159,358,138.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,095,000.00</b>	<b>157,654,230.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	1,808,073.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,095,000.00	155,846,157.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>147,242.00</b>	<b>1,703,908.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	147,242.00	1,703,908.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>116,003,494.32</b>	<b>68,547,174.81</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>116,003,494.32</b>	<b>68,547,174.81</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,030,171,000.00</b>	<b>1,421,031,974.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,300,000.00</b>	<b>1,003,919.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,300,000.00</b>	<b>1,003,919.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	200,000.00	200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00
120009	Бусад орлого	1,100,000.00	803,919.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,028,871,000.00</b>	<b>1,420,028,055.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,005,461,000.00</b>	<b>1,383,209,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,005,461,000.00	1,383,209,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>23,410,000.00</b>	<b>35,010,782.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	7,100,782.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,410,000.00	22,910,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>1,808,073.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	1,808,073.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,030,171,000.00</b>	<b>1,419,981,974.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,030,171,000.00</b>	<b>1,419,981,974.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,024,928,758.00</b>	<b>1,260,623,836.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>847,323,599.00</b>	<b>1,039,835,310.00</b>
210101	Үндсэн цалин	674,615,399.00	735,084,110.00
210102	Нэмэгдэл	142,521,100.00	274,564,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,187,100.00	30,187,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>105,795,800.00</b>	<b>140,377,700.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	71,941,200.00	98,784,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,463,700.00	10,398,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,770,900.00	8,318,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,692,700.00	2,079,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,927,300.00	20,796,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,799,600.00</b>	<b>25,419,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,731,200.00	4,523,500.00
210302	Түлш, халаалт	17,993,400.00	20,631,800.00
210303	Цэвэр, бохир ус	75,000.00	264,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>8,361,859.00</b>	<b>7,770,440.00</b>
210401	Бичиг хэрэг	1,037,700.00	763,140.00
210402	Тээвэр, шатахуун	4,970,100.00	4,274,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,219,259.00	2,424,800.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	134,800.00	307,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>464,500.00</b>	<b>464,500.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	464,500.00	464,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,341,800.00</b>	<b>568,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,312,700.00	508,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	66,300.00	60,300.00
210604	Урсгал засвар	1,962,800.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,443,800.00</b>	<b>2,981,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,443,800.00	2,981,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,303,900.00</b>	<b>43,206,786.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,099,800.00	41,402,386.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	277,200.00	275,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	401,300.00	321,518.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,800.00	114,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	24,700.00	24,700.00
210807	Газрын төлбөр	386,100.00	1,068,382.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,093,900.00</b>	<b>00.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,093,900.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,242,242.00</b>	<b>159,358,138.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>5,095,000.00</b>	<b>157,654,230.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	1,808,073.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	5,095,000.00	155,846,157.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>147,242.00</b>	<b>1,703,908.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	147,242.00	1,703,908.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>1,050,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>1,050,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>1,050,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>1,050,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,050,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-1,050,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	359,685,889.97	-77,784,066.15	869,642,567.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	-6,557,200.000	6557200	0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	587,740,743.91	353,128,689.97	-71226866,15	869,642,567.73
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	116,003,494.32	116,003,494.32
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	353,128,689.97	44,776,628.17	985,646,062.05
D01	2020 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	353,128,689.97	44,776,628.17	985,646,062.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	191,522.00	191,522.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	587,740,743.91	353,128,689.97	44,968,150.17	985,837,584.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-191,522.00	00.00	-191,522.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	68,547,174.81	68,547,174.81
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	352,937,167.97	113,515,324.98	1,054,193,236.86



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,383,409,200.00	1,382,513,209.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,383,409,200.00	1,382,513,209.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,227,563,000.00	1,226,667,052.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,039,835,400.00	1,039,835,310.00
210101	Үндсэн цалин	735,084,200.00	735,084,110.00
210102	Нэмэгдэл	274,564,100.00	274,564,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,187,100.00	30,187,100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	140,377,700.00	140,377,700.00
210201	Тэтгэврийн даатгал	98,784,300.00	98,784,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,398,300.00	10,398,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,318,700.00	8,318,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,079,700.00	2,079,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,796,700.00	20,796,700.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,419,300.00	25,419,300.00
210301	Гэрэл, цахилгаан	4,523,500.00	4,523,500.00
210302	Түлш, халаалт	20,631,800.00	20,631,800.00
210303	Цэвэр, бохир ус	264,000.00	264,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,777,900.00	7,770,440.00
210401	Бичиг хэрэг	770,600.00	763,140.00
210402	Тээвэр, шатахуун	4,274,700.00	4,274,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,424,800.00	2,424,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	307,800.00	307,800.00
2105	<b>Нормативт зардал</b>	464,500.00	464,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	464,500.00	464,500.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,254,800.00	1,254,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,194,500.00	1,194,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	60,300.00	60,300.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,981,000.00	2,981,000.00
210702	Дотоод албан томилолт	2,981,000.00	2,981,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,162,200.00	8,564,002.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,354,800.00	6,759,602.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	275,000.00	275,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	321,600.00	321,518.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,800.00	114,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,700.00	24,700.00
210807	Газрын төлбөр	1,071,300.00	1,068,382.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	290,200.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	290,200.00	0.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	155,846,200.00	155,846,157.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	155,846,200.00	155,846,157.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	155,846,200.00	155,846,157.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,383,409,200.00	1,382,513,209.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,383,209,200.00	1,381,509,290.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,383,209,200.00	1,381,509,290.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	200,000.00	1,003,919.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	1,003,919.00
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	90.00	90.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	83.00	83.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>90.00</b>	<b>90.00</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	90.00	90.00



## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>35,006,784.00</b>
		<b>23,406,900.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>35,006,784.00</b>
		<b>23,406,900.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		35,006,784.00
		<b>23,406,900.00</b>	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		35,006,784.00
		23,406,900.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,406,900.00	35,006,784.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		35006784.00
		23,406,900.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		35,006,784.00
		23,406,900.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	20,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00	7,100,782.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,406,900.00	22,906,002.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Ч.Оюунчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 10-аас 2021 оны 02 дугаар сарын 17-ны хооронд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 161 тоот албан бичгээр ирүүлсэн байна.



### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Баянхонгор аймгийн уур амьсгал, усны нөөц, орчны бохирдолд байнга хяналт, шинжилгээ, судалгаа хийж, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд Ус цаг уур орчны хяналт шинжилгээний үнэн зөв, чанартай мэдээ, мэдээллээр шуурхай үйлчлэх, байгаль цаг агаарын аюултай үзэгдэл, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэрэмжлүүлэх явдал юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Тээврийн хэрэгслийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын багц хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний газраас Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 1144602.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 22892.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1495798.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 29916.0 мянган төгрөгөөр тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68547.2 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	227,761.9	267,702.2	39,940.3
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	803.9	-	(803.9)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	226,958.0	267,702.2	40,744.2
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	757,884.1	786,491.1	28,606.9
Үндсэн хөрөнгө	1,161,712.9	1,203,634.7	41,921.8
Хуримтлагдсан элэгдэл	(403,828.7)	(417,143.7)	(13,314.9)
<b>Нийт хөрөнгө</b>	985,646.1	1,054,193.2	68,547.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	985,646.1	1,054,193.2	68,547.2
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	985,646.1	1,054,193.2	68,547.2

Авлагын дансны үлдэгдэл 803.9 мянган төгрөгийг 2020 оны 12-р сарын 30-нд барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 256702.2 мянган төгрөг болж өмнөх оноос 40744.2 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалд 33792.0 мянган төгрөгийн цаг уурын автомат станц МА-ВА1, 411052.36 маркийн 486.1 мянган төгрөгийн 30 ширхэг пүүжинг Цаг уур, орчны шинжилгээний газраас үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1203634.7 мянган төгрөг болж өмнөх оноос 41921.8 мянган төгрөгөөр өссөн нь Цаг уур, орчны шинжилгээний газрын 2020.03.30-ны өдрийн А/14 тоот тушаалаар “Байгаль орчин, уур амьсгалын сан Арабын Нэгдсэн Эмират улсын уур амьсгалын өөрчлөлт, төсөл”-өөс 2019 оны 9 сард хүлээлгэн өгсөн 56267.6 мянган төгрөгийн үнэтэй Мицубиши Л200 маркийн автомашиныг үнэ төлбөргүй орлого авсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны А1/1035 тоот албан бичгийг үндэслэн 2825.5 мянган төгрөгийн хөрөнгө акталсан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 359 тоот албан бичгийн дагуу УАЗ 322069 маркийн 79-05 БНА улсын дугаартай 14600.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй элэгдлээ бүрэн нөхсөн автомашиныг дуудлага худалдаанд оруулж 1200.0 мянган төгрөгөөр худалдан борлуулж данснаас хассан зэрэгтэй холбоотой байна.

Бусад хөрөнгөд бүртгэлтэй 1562.7 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгөд залруулан бүртгэсэн болно.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1054193.2 мянган төгрөг ба өмнөх оноос 309961.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 1564345.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 123099.9 мянган төгрөгөөр буюу 24.6 хувиар өссөн нь 81195.3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого нэмэгдэж, улсын төсвөөс олгох санхүүжилт өмнөх оныхоос 377748.2 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.



Нийт зардал 1495798.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 357418.1 мянган төгрөгөөр буюу 31.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал 226631.3 мянган төгрөг, урсгал засвар 8219.8 мянга, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 150751.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1283950.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1283950.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 99458.8 мянган төгрөгөөр цалингийн зардлыг нэмэгдүүлж 1383409.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 1383209.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 200.0 мянган төгрөг нийт 1383409.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж улсын төсвөөс 1383209.2 мянган төгрөгийн санхүүжилт авч туслах үйл ажиллагааны орлого 200.0 мянган төгрөг орж, гүйцэтгэлээр 1382513.2 мянган төгрөг зарцуулж 1699.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 598.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 290.2 мянган төгрөгөөр батлагдсан зардлыг хэмнэсэн байна.

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
ХӨТӨЛБӨР 71408	1,227,563,000.00	1,226,667,052.00	895,948.00	-
АРГА ХЭМЖЭЭ 80101	1,227,563,000.00	1,226,667,052.00	895,948.00	-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,227,563,000.00	1,226,667,052.00	895,948.00	88.33
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,227,563,000.00	1,226,667,052.00	895,948.00	88.33
Бараа, үйлчилгээний зардал	1,227,563,000.00	1,226,667,052.00	895,948.00	99.54
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,039,835,400.00	1,039,835,310.00	90.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,377,700.00	140,377,700.00	-	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,419,300.00	25,419,300.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	7,777,900.00	7,770,440.00	7,460.00	99.90
Нормативт зардал	464,500.00	464,500.00	-	100.00
Эд хогшил худалдан авах	1,254,800.00	1,254,800.00	-	100.00
Томлолт, зочны зардал	2,981,000.00	2,981,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	9,162,200.00	8,564,002.00	598,198.00	41.50
Бараа үйлчилгээний бусад зардал	290,200.00	-	290,200.00	-
ХӨТӨЛБӨР 71408	155,846,200.00	155,846,157.00	43.00	



АРГА ХЭМЖЭЭ 80802	155,846,200.00	155,846,157.00	43.00	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	155,846,200.00	155,846,157.00	43.00	-
Бусад урсгал шилжүүлэг	155,846,200.00	155,846,157.00	43.00	-
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	155,846,200.00	155,846,157.00	43.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,383,409,200.00	1,381,709,290.00	1,699,910.00	99.88
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,383,209,200.00	1,381,509,290.00	1,699,910.00	99.88
Улсын төсвөөс санхүүжих	1,383,209,200.00	1,381,509,290.00	1,699,910.00	99.88
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,000.00	200,000.00	-	100.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00	-	100.00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт дансаар гүйлгээ хийгдээгүй болно.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулахаас 135 мэдээллийг хугацаанд нь байршуулж 2020 оны 5-р сард 3 мэдээлэл, 11 сарын 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. 11 сард хөдөө томилолтоор явж байсан тул хоцорч мэдээлсэн.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон
1	Бүтэн жил	11	9	9	0
2	Хагас жил	4	4	4	0
3	Улирал бүр	4	4	4	0
4	Сар бүр	12	36	33	3
5	Тухай бүр	12	96	85	11
	Нийт		149	135	14

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2020.04.15-ны өдрийн 69 дугаартай албан тоотоор ирүүлсэн биелүүлж ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	1527.2	3	1527.2	-	-	
Албан шаардлага					-	-	
Зөвлөмж	3	112.5	3	112.5	-	-	
Нийт дүн		1639.7		1639.5	-	-	

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9657.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2025.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 1652.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 5980.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Санхүүгийн тайлангийн залруулга

1. Шатахууны картын орлогыг бараа материалын орлоготой тулган шалгахад 2020 онд НИК ХХК-аас олгосон шатахууны хөнгөлөлт 462,3 мянган төгрөгийн орлогыг үнэ төлбөргүй орлогоор бүртгээгүй байсныг санхүүгийн тайланд үнэ төлбөргүй орлогоор бүртгэж залруулав.

2. Санхүүгийн программ, программ хангамж, цалингийн программ 1562.7 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг бусад үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсныг биет бус хөрөнгийн программ хангамжид шилжүүлэн бүртгэж залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 7632.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1652.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 5980.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй УЦУОШГ-аас 2008, 2013 онд ирүүлсэн 2 мотоцикл, 2014 онд Техник импорт ХК-аас үнэ төлбөргүй олгосон 2 мотоцикл нийт 5980.0 мянган төгрөгийн 4 мотоцикл байгууллагын нэр дээр бүртгэлгүй, гэрчилгээ аваагүй байна.

Энэ нь Авто тээврийн хэрэгслийн тухай хуулийн 17.1."Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ." гэсэн заалт, "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Хөрөнгөд бүртгэлтэй ашиглагдаж байгаа мотоциклыг тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаар авах талаар баримт материалыг бүрдүүлж, холбогдох байгууллагуудад хандаж арга хэмжээ авах.

2. Ажиллагсдын цалингийн урьдчилгааг суутган тооцсон эсэхийг тулган шалгахад 5 хүний 1070.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй, авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэ зөв байх", 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14,4,2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалт "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Цалингийн урьдчилгаа суутган тооцоогүй 1070.0 мянган төгрөгийн холбогдох 5 ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2020.03.13-ны өдрийн Б/39 тоот тушаалаар Ч.Оюунчимэгт албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 30 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байхад 4 сарын цалингаас суутган 5 сард суутган тооцолгүй бүтэн цалингаар тооцож 289.7 мянган төгрөг илүү олгосон.

Мөн сахилгын шийтгэлийн хугацаа дуусгавар болоогүй байхад Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2020 оны 7-р сарын А/149 тоот тушаалаар 2020 оны хагас жилийн үр дүнгийн урамшуулал нэг сарын цалингийн 40 хувиар тооцож 292.8 мянган төгрөг





шийтгэлийн хугацаа дуусгавар болоогүй байхад Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2020 оны 7-р сарын А/149 тоот тушаалаар 2020 оны хагас жилийн үр дүнгийн урамшуулал нэг сарын цалингийн 40 хувиар тооцож 292.8 мянган төгрөг олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 31.4."Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно" гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн: Илүү олгосон 582.6 мянган төгрөгийг Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга Ч.Оюунчимэгээр 582.6 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

## 2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу холбогдох мэдээллийн [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлсэн эсэхийг шалгахад нийт 149 мэдээлэл байршуулахаас 135 мэдээллийг хугацаанд нь байршуулж 2020 оны 5-р сард 3 мэдээлэл, 11 сард тавих бүх мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна

2.2 Эрсдэл: Шилэн дансны мэдээллийн үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулаагүй байх

2.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1<sup>1</sup>, 7.1.3<sup>2</sup> заалтын дагуу шилэн дансанд мөн хуулийн 6 дугаарт заасан мэдээллээс байгууллагын удирдлагын гаргасан шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлж байх.

2.3 Аудитын санал дүгнэлтийн үндэслэл:

Бид Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

### “Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдсан болно.

Гурав. Баталгаажуулалт

Тайлангийн хураангуй бэлтгэсэн:

Ахлах аудитор

М.Алтантуяа Огноо:2021.02.18

Анхан шатны чанарын хяналт хийсэн:

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер

А.Цээням Огноо: 2021.02.18

Хоёр дахь шатны чанарын хяналт хийсэн:

Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор

Б.Мөнхбат Огноо: 2021.02.18

<sup>1</sup> Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ:

<sup>2</sup> .тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан.



### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:		
2020			БНА-2021/156/СТА-ТШЗ		
Шалгагдсан байгууллагын нэр:		Баянхонгор аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв		Мянган төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Автотээврийн хэрэгслийн гэрчилгээг данс бүртгэлтэй тулган шалгахад хөрөнгөд бүртгэлтэй 5980.0 мянган төгрөгийн 4 мотоцикл байгууллагын нэр дээр бүртгэлгүй, гэрчилгээ аваагүй байна. Энэ нь Авто тээврийн хэрэгслийн тухай хуулийн 17.1."Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн тээврийн хэрэгсэл өмчилж авснаас хойш 72 цагийн дотор, ашиглалтаас хассанаас хойш нэг сарын дотор аймаг, нийслэл дэх авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллагад бүртгүүлнэ." гэсэн заалт, "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна	5980.0	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	Ч.Оюунчимэг, Б.Энхжаргал
2	Ажиллагсдын цалингийн урьдчилгааг суутган тооцсон эсэхийг тулган шалгахад 5 хүний 1070.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй, авлагаар бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 "үнэ зөв байх", 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14,4,2 бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэсэн заалт "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.	1070.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Ч.Оюунчимэг, Б.Энхжаргал
3	Нийт цалингийн зардлыг журналын бичилт болон цалингийн цэстэд давтан тооцоолол хийхэд Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2020.03.13-ны өдрийн Б/39 тоот тушаалаар Ч.Оюунчимэгт сахилгын шийтгэл ногдуулах тухай тушаалаар 3 сарын хугацаагаар 30 хувь бууруулах шийтгэл ногдуулсан байхад 5 сард суутгалыг тооцолгүй бүтэн цалингаар тооцож 289.7 мянган төгрөг илүү олгосон. Мөн Сахилгын шийтгэлийн хугацаа дуусгавар болоогүй байхад Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2020 оны 7-р сарын А/149 тоот тушаалаар 2020 оны хагас жилийн үр дүн нэг сарын цалингийн 40 хувиар тооцож 292.8 мянган төгрөг олгож Хөдөлмөрийн тухай хуулийн 31.4."Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно" гэсэн заалтыг зөрчсөн байна.	582.6	Төлбөрийн акт тогтоох	Дарга, нягтлан бодогч	Ч.Оюунчимэг, Б.Энхжаргал
4	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу холбогдох мэдээллийн shilendans.gov.mn сайтад хуулийн хугацаанд үнэн зөв мэдээлсэн эсэхийг шалгахад нийт 149 мэдээлэл байршуулахаас 135 мэдээллийг хугацаанд нь байршуулж 2020 оны 5-р сард 3 мэдээлэл, 11 сарын 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Ч.Оюунчимэг, Б.Энхжаргал
<b>ДҮН</b>		<b>7632.6</b>			

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_